



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 2/02

Урт

Хурлын хороодыг байгуулж,
тэдгээрийн ажиллах журмыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "в", 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянах чиг үүрэг бүхий дор дурдсан хороодыг байгуулсугай.

- 1.1. Нийгмийн бодлого, эрх зүйн хороо
- 1.2. Эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн хороо
- 1.3. Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны хороо
- 1.4. Уул уурхай дэд бүтцийн хороо

2. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороодын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Журмыг хэрэгжүүлж, идэвх санаачлагатай ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2013 оны 06 сарын 10-ны өдрийн 4/01 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.ОТГОНБАЯР



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
хуралдааны 2/02 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт



**Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хороодын бүрэлдхүүн**

№	Хорооны нэр	Дарга	Гишүүд
1	Нийгмийн бодлого хууль эрх зүйн хороо	Г.Гангамаа	Б.Цэндсүрэн, Л.Пүрэвдорж, Д.Гантулга Н.Эрхэмбаяр
2.	Эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн хороо	Ц.Дэлгэрмаа	У.Нямсүрэн, Б.Дэжид, Ц.Ганбаатар, Н.Энхмандах
3	Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны хороо	О.Батмөнх	И.Нямаа, Н.Мэндбаяр, Н.ГАлаахүү, Г.Цогтбаатар, Д.Болормаа
4	Уул уурхай, дэд бүтцийн хороо	Ц.Манлайбаатар	Б.Отгонбаяр, Ж.Мөнхбаяр, Д.Айлтгүй, Ц.Баатар, Л.Пүрэвдорж

___оОо___

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
хуралдааны 2/02 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллахад энэхүү журмын зорилго оршино.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаагаар Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны Төлөөлөгчдийн дотроос сонгох
- 1.2 Хороод хяналт шалгалт хийхдээ ажил хариуцсан мэргэжилтэн, ахмад, туршлагатай хүмүүс, хууль хяналт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл, иргэдийг өргөнөөр татан оролцуулах ба удирдамжаа сумын ИТХ-ын даргаар батлуулах
- 1.3 Хороод хариуцсан ажлын чиглэлээр асуудлыг судлах, танилцах, хяналт хийх, тухайн асуудлаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд санал оруулах, дүгнэлт гаргах
- 1.4 Сумын ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих
- 1.5 Хариуцсан ажлын чиглэлээр хууль тогтоомжийн төсөлд орон нутгийн төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал асуулга зохион байгуулах, "Иргэний танхим"-ын нээлттэй хэлэлцүүлэг, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах
- 1.6 Хороод хариуцсан салбарын байгууллага, иргэдтэй уулзаж ярилцах, ажил байдалтай нь танилцах, тухайн чиглэлээр гарсан санал санаачлага, өргөдөл гомдлыг шалгаж, шийдвэрлэх
- 1.7 Хороод Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж тухайн жилийн ажлын төлөвлөгөөг 1 сард багтаан төлөвлөж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар батлуулан хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 11-р сард хуралдах хуралд тайлагнана
- 1.8 Хурлын төлөөлөгч нь бусад хороодын хуралд оролцож санал гаргах, үг хэлэх эрхтэй ба өөрийн харьяалах хорооны хуралд асуудал таслах, санал шүүмжлэл хэлэх эрхтэй оролцох
- 1.9 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, төсвийн гүйцэтгэлд хяналт хийх, дүгнэлт гаргах
- 1.10 Хорооны үйл ажиллагаанд ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас тээврийн хэрэгсэл, бичиг хэрэг, шатахууны дэмжлэг тусалцаа үзүүлж ажиллана.

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХОРОО

- 2.1 Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, өрх гэр бүлийн хөгжил, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын бодлого үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээлэл тайланг сонсох, санал дүгнэлт гаргах
- 2.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлд тусгасан төсөл хөтөлбөрүүдийг боловсруулахад оролцох, урьдчилан хэлэлцэж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд санал дүгнэлт оруулах
- 2.3 Төрийн үйлчилгээний байгууллагууд ард иргэдэд үйлчилж буй байдал, иргэд хүүхэд залуучуудын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар хийгдэж буй ажилд хяналт хийх
- 2.4 Нийгмийн халамж үйлчилгээ, нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох байгууллагуудын мэдээллийг хэлэлцэх.
- 2.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, тогтоол шийдвэр, заавар журмын хэрэгжилтэд хяналт тавих
- 2.6 Шинээр гарч байгаа хуулийн төслүүдэд иргэдийн санал авах, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах
- 2.7 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл холбогдох байгууллагын мэдээллийг сонсох, үйл ажиллагаанд хяналт хийх
- 2.8 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, албан газрууд ажилтнууддаа хууль эрх зүйн мэдээлэл өгөх, хуулийн сан бүрдүүлэх, ард иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд хяналт хийх
- 2.9 Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож үйл ажиллагааны явцад хяналт хийх
- 2.10 Хүний эрх, эрх чөлөө, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, өргөдөл гомдлын асуудлыг шийдвэрлэсэн байдалд хяналт хийх

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ӨМЧ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН ХОРОО

- 3.1 Төсвийн болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих
- 3.2 Төсвийн зарцуулалт, тендерийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх, үр дүнг тооцох
- 3.3 Сумын нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, төсөв, орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж дүгнэлт гарган ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулах
- 3.4 Орон нутгийн төсвийн орлогын биелэлтэд хяналт тавих, үүрэг чиглэл өгөх
- 3.5 Орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих, өмчийн асуудлаар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд санал дүгнэлт оруулах
- 3.6 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОРОО

- 4.1 Мал аж ахуйг хөгжүүлэх, цөөн малтай иргэдийг малжуулах, малчдын ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх,

- уул уурхайн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд хяналт хийж асуудал санаачлах
- 4.2 Малчны хөдөлмөр хөнгөвчилсэн шинэ техник технологийг судлан, нэвтрүүлэх санал санаачлага гаргах, мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт хийх
 - 4.3 Газар тариалан эрхлэгчид, мод тарьж ургуулсан иргэд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих
 - 4.4 Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийн ашиглах, нөхөн сэргээх байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт хийх, дүгнэлт гаргах
 - 4.5 Газрын доорх гүний усны ашиглалт хамгаалалт, ай савыг хамгаалалтад авах, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны ашиглалтын байдалд хяналт хийх
 - 4.6 Сумын төв болон уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн орчинд агаарын бохирдол, хог хаягдал, байгаль орчны асуудалд хяналт, судалгаа хийх санал дүгнэлт гаргах
 - 4.7 Аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн үзэсгэлэнт газрууд, түүхэн дурсгалт, соёлын өвийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт хийх, санал дүгнэлт гаргах

ТАВ. УУЛ УУРХАЙ, ДЭД БҮТЦИЙН ХОРОО

- 5.1 Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн судалгаа гаргаж, үйл ажиллагаанд хяналт тавих, уул уурхайн чиглэлээр бодлого боловсруулах, санал дүгнэлт гаргаж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулах
- 5.2 Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй орон нутгийн бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаанд хяналт хийх
- 5.3 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж татвар бүрдүүлэлтэд хяналт тавих
- 5.4 Уул уурхайн салбарын хөгжилд тулгуурласан зам тээвэр, эрчим хүч, барилга, хот байгуулалтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт тавих
- 5.5 Газар зохион байгуулалт, дэд бүтэц, бүтээн байгуулалт, орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаа, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хяналт хийх
- 5.6 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр санал дүгнэлт гаргах
- 5.7 Сумын эрчим хүчний хангамж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд хяналт хийх